



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Ардчилсан намаас ирүүлсэн  
хүсэлтийг хэлэлцэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, Х.Батсүрэн, С.Батдэлгэр, Б.Батцэрэн, Г.Банзрагч, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Г.Цагаанцоож, Д.Цолмон, Б.Цогт, Ц.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ардчилсан намаас ирүүлсэн Үндсэн дүрмийн хороо, Дотоод сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсныг, намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт болон намын даргаар О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч Г.Цагаанцоож, Д.Цолмон, Х.Батсүрэн нарын илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Нэг. Ардчилсан Намын /цаашид АН гэх/ Хэрэг эрхлэх газрын дарга А.Цэрэнбатаас 2021.03.10-ны өдөр ирүүлсэн хүсэлтэд: “Улс төрийн намын тухай хууль /УТНТХ/-ийн 13.4. “Намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм ...өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно.” гэж зааснаар Ардчилсан намын төлөөллийн төв байгууллага /намын үндсэн дүрмийн 5.13.1/ болох Үндэсний бодлогын хорооны ээлжит бус цахим хурлын 2021.03.04-ний өдрийн 09, 10, 11 дүгээр тогтоолыг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7.1.3. “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн;”, Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 7.6 дахь хэсэгт “Улсын дээд шүүх улс төрийн намыг энэ хууль болон бусад хуульд заасны дагуу бүртгэнэ.” гэж тус тус зааснаар бүртгүүлэх нь зүйтэй байна. Иймд Ардчилсан намын Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/ болон Дотоод сонгуулийн хороо /ДоСХ/-ны гишүүдийн эрх нь /АН/-ын Үндсэн дүрмийн 5.21.5 дахь хэсэгт “ҮДХ-ны дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.”, 5.22.5.7-д “Дотоод сонгуулийн хорооны дарга, дэд дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна”, 5.22.5.8 дахь хэсэгт зааснаар “ДоСХ-ны даргыг гишүүд дотроосоо нэрээ дэвшүүлж, санал хураалтаар сонгоно.

ДоСХ-ны дарга нь улиран сонгогдохгүй.” гэх заалтуудыг үндэслэн Их хурлаас сонгогдсон бие бүрэлдэхүүнд Үндэсний бодлогын хороо 2021.03.04-ний өдрийн ээлжит бус цахим хурлаар өөрчлөлт оруулсныг бүртгүүлэх хүсэлтэй байна.” гэжээ.

Хоёр. АН-ын Хэрэг эрхлэх газрын дарга /цаашид ХЭГ гэх/ А.Цэрэнбатаас 2021.03.24-ний өдөр ирүүлсэн хүсэлтэд: Улс төрийн намын тухай хуулийн 13.4-д “Намын Их хурлаар батлагдсан намын дүрэм ...нэмэлт, өөрчлөлт оруулах, ...асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж зааснаар Ардчилсан намын төлөөллийн төв байгууллага /намын үндсэн дүрмийн 5.13.1/ болох Үндэсний бодлогын хороо нь Үндсэн дүрэмд 2021.03.04-ний өдрийн 06 дугаар тогтоол, 2021.03.12-ны өдрийн ээлжит бус цахим хурлын 05 дугаар тогтоолуудаар нэмэлт өөрчлөлт оруулсныг бүртгэж өгнө үү” гэжээ.

Гурав. АН-ын ХЭГ-ын дарга П.Нүрзэд 2021.04.08-ны өдөр ирүүлсэн хүсэлтдээ: Ардчилсан намын ээлжит бус Их хурал 2021.04.03-ны өдөр хуралдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван Ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.” гэж, Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийг удирдлага болгон намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа, удирдлагын бүрэн эрхтэй холбоотой маргаанаа мөн хуулийн 13.9-д “Намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой маргааныг шүүх хянан шийдвэрлэхгүй. Энэхүү маргааныг намын эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэнэ.” хэмээн заасны дагуу Улсын Дээд Шүүхэд бүртгэлтэй намын Үндсэн дүрмийн хүрээнд шийдвэрлэж Одонгийн Цогтгэрэлийг Намын даргаар сонгож батламжилсан тул Ардчилсан намын удирдлагатай холбоотой өмнө нь бүртгэгдсэн мэдээлэлд өөрчлөлт оруулж, Ардчилсан намын даргаар О.Цогтгэрэлийг бүртгэж өгнө үү” гэжээ.

Дөрөв. АН-ын ХЭГ-ын дарга А.Цэрэнбатын 2021.04.19-ний өдрийн ХЭГ/109 дүгээр албан бичгээр ирүүлсэн мөн өдрийн хүсэлтдээ: “Ардчилсан намын дарга М.Тулгатыг ёсчлон батламжилсан, Ардчилсан намын ээлжит бус цахим XI Их хурлын болон Үндэсний бодлогын хорооны хуралдааны материалыг 2021.04.16-ны өдөр 21 хадгаламжийн нэгж үүсгэн, үдэж хавтаслан хүргүүлсэн ба хавсралтаар дотоод товъёогыг дэлгэрэнгүй гаргаж хүргүүлэв” гэжээ.

Хүсэлт, түүнтэй холбогдуулан ирүүлсэн баримтыг хуралдаанаар хянан хэлэлцээд

ҮНДЭСЛЭХ нь:

АН-аас гаргасан дээрх хүсэлтүүдийг дараах байдлаар нэгтгэн хэлэлцэв.

Нэг. Үндсэн дүрмийн хороо болон Дотоод сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсныг бүртгүүлэх хүсэлтийн талаар:

Уг хүсэлтэд АН-ын ҮБХ-ны ээлжит бус цахим хурлын “Үндсэн дүрмийн хороо, Дотоод сонгуулийн хорооны гишүүдийн бүрэн эрхийг баталгаажуулах тухай” тогтоол /2021.03.04 №9/, “Дотоод сонгуулийн хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” тогтоол /2021.03.04 №10/, Дотоод сонгуулийн хорооны гишүүд /АН-ын ҮБХ-ны ээлжит бус цахим 2021 оны 03 сарын 04-ний өдрийн хурлын 10 дугаар тогтоолын хавсралт/, мөн өдрийн хурлын “Үндсэн дүрмийн хорооны гишүүдийг чөлөөлж, томилох тухай” тогтоол №11, Үндсэн дүрмийн хорооны гишүүд /№11 тогтоолын хавсралт/ нийт 5 хуудас баримтыг хавсарган ирүүлсэн байна.

Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт “Улсын дээд шүүх улс төрийн намыг энэ хууль болон бусад хуульд заасны дагуу бүртгэнэ.” гэж, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт”-ийг улсын бүртгэлд бүртгэнэ. Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “хуулийн этгээдийн мэдээлэл” гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа энэ хуулийн 10.1-д заасан мэдээллийг бүртгэхээр, түүнчлэн Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т зааснаар намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээр тусгайлан зохицуулсан.

Иймээс “Дотоод сонгуулийн хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 10 дугаар тогтоолын хавсралтад заасан Дотоод сонгуулийн хорооны гишүүд, “Үндсэн дүрмийн хорооны гишүүдийг чөлөөлж, томилох тухай” 11 дугаартай тогтоолын хавсралтад заасан Үндсэн дүрмийн хорооны гишүүдийн бүртгэл нь хуулийн дээрх зохицуулалтад хамаарахгүй байна.

Хоёр. Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн талаар:

2.1. АН-ын ХЭГ-ын дарга А.Цэрэнбат Үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг гаргаж, АН-ын Үндэсний бодлогын хороо /цаашид ҮБХ гэх/-ны 2021.03.04-ний өдрийн ээлжит бус цахим хурлын тооллогын болон редакцийн комисс байгуулах, хурлын дарга, тэргүүлэгчдийг сонгох, хэлэлцэх асуудал батлах тухай 01, 02, 03, 04 дүгээр тогтоол, Үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж батлах тухай 06 дугаар тогтоол, хавсралт, Үндсэн дүрмээс хасагдах заалтуудыг хэлэлцэж баталсан 07 дугаар тогтоол, хавсралт, Үндсэн дүрэмд шинээр нэмэгдсэн заалтыг батлах тухай 08 дугаар тогтоол, хавсралтыг ирүүлжээ.

Мөн ҮБХ-ны 2021.03.12-ны өдрийн ээлжит бус цахим хурлын тооллогын болон редакцын комисс байгуулах, хурлын дарга тэргүүлэгчдийг сонгох, хэлэлцэх асуудал батлах тухай 01, 02, 03, 04 дүгээр тогтоол, Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 05 дугаар тогтоол, хуралд оролцогчдын бүртгэл болон Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг хавсаргаж ирүүлсэн байна.

А/ АН-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан 2021.04.02-ны өдөр ирүүлсэн 01/99 тоот албан бичигт “...Ардчилсан намыг төлөөлөх эрхгүй этгээд болох С.Эрдэнэ, А.Цэрэнбат, Х.Алтанхуяг нар нь ...намын төлөөллийн төв байгууллага (Үндэсний бодлогын хороо) дотоод бүтцийн байгууллага (Үндсэн дүрмийн хороо, Дотоод сонгуулийн хороо)-д хууль бус өөрчлөлт оруулж тэрхүү хууль бус

бүрэлдэхүүнээр АН-ын үндсэн дүрэмд дүрмийн бус нэмэлт, өөрчлөлт оруулан бүртгүүлэхээр хүсэлт гаргасан байна. ...намын дүрмийн 5.12.4-т “Их хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ”, 5.12.4.1-д “Намын Үзэл баримтлал, Үндсэн дүрэм, бусад журам мөрийн хөтөлбөр батлах;” хэмээн Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг намын эрх барих дээд байгууллага болох “Намын Их Хурал”-д олгогдсон, дүрмийн 5.12.4.10-т “ Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол Намын Их хурлын бүрэн эрхийг ҮБХ-д шилжүүлэхийг хориглоно;” гэж Их хурлын бүрэн эрхийг ямар нэгэн хэлбэрээр шилжүүлэхийг хориглосон. Иймд хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэхгүй байхыг албан ёсоор мэдэгдэж байна” гэжээ.

Б/ АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид ЕНБД гэх/ Ч.Өнөрбаяр 2021.04.05-ны өдөр ирүүлсэн 78 тоот албан бичигт АН-ын ХЭГ-с 2021.03.09-ний өдрийн ХЭГ/78, 2021.03.23-ны өдрийн ХЭГ/86 дугаар тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн болно гэжээ.

Эдгээр нь намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсныг бүртгүүлэх хүсэлттэй адил агуулгатай гэж үзэв.

2.2. Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсныг бүртгүүлэх тухай хүсэлтийг хэлэлцээд дараах үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэх нь зүйтэй гэж дүгнэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд Улсын дээд шүүх хяналт тавина. Нам өөрийн дүрэм, мөрийн хөтөлбөртөө оруулсан өөрчлөлтийг 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлнэ.” гэж заажээ.

Дээрх зохицуулалтаар Улсын дээд шүүх хяналт тавихдаа тухайн намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэлэлцэн баталсан үйл ажиллагаа болон дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, утга санаа, үзэл баримтлал нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг тогтооно.

АН-ын 2018.12.05-ны өдрийн 9 дүгээр Их хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан намын дүрмийг Улсын дээд шүүх бүртгэсэн байх тул энэхүү дүрэм тухайн намын үйл ажиллагаандаа баримтлах, дагаж мөрдөж, хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг болно.

Дүрмийн 5.12.1-д намын эрх барих дээд байгууллага нь Ардчилсан намын Их хурал мөн.

5.12.2-т Их хурлын ээлжит хуралдаан 4 жилд 2-с доошгүй удаа хуралдана. Их хурлын ээлжит, ээлжит бус хуралдааныг ҮБХ-ны нийт гишүүдийн ердийн олонх /50-с дээш хувь/-ийн саналаар эсвэл намын дарга зарлан хуралдуулна.

5.12.4.1-д Их хурал нь намын үзэл баримтлал, үндсэн дүрэм, бусад журам, мөрийн хөтөлбөр батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.12.4.10-т Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол намын Их хурлын бүрэн эрхийг ҮБХ-д шилжүүлэхийг хориглоно.

9.1.1-д намын үзэл баримтлал, Үндсэн дүрэм, бусад журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгын санал боловсруулах, Их хуралд өргөн барьж, хэлэлцүүлэх асуудлыг ҮБХ-ны үзэл баримтлал, Үндсэн дүрмийн зөвлөлийн саналд үндэслэн ҮБХ-оос Их хуралд өргөн барина гэж тус тус заажээ.

Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “намын Их хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж заасан хэдий ч дүрмийн дээрх зохицуулалтаар намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах нь намын Их хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

Түүнчлэн, ҮБХ намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй эсэх талаар намын дотоод хүрээнд маргаантай асуудал үүссэн байна.

АН-ын ҮБХ нь үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.2.1, 13.9 дэх заалт болон намын дүрэмд нийцээгүй байна.

Гурав. Намын даргаар О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг тус тус бүртгүүлэх хүсэлтийн талаар:

3.1. АН-ын ХЭГ-ын дарга П.Нүрзэд 2021.04.08-ны өдөр ирүүлсэн хүсэлтдээ “...О.Цогтгэрэлийг намын даргаар сонгож батламжилсан тул ...намын хувийн хэрэг дэх намын удирдлагатай холбоотой өмнө нь бүртгэгдсэн мэдээлэлд өөрчлөлт оруулж, бүртгэж өгнө үү” гэжээ.

Хүсэлтэд өргөдөл, АН-ын ээлжит бус Их хурлын тов, хэлэлцэх асуудал, хуралд бэлтгэх ажлын хэсгийг батлах тухай ҮБХ-ны 2021.03.11-ний өдрийн 20/10 дугаар тогтоол, хавсралт, АН-ын дотоод сонгуулийг товлон зарлах тухай Дотоод сонгуулийн хорооны 2021.02.24-ний өдрийн 03 тогтоол, уг тогтоолд өөрчлөлт оруулах тухай 04 тогтоол, Дотоод сонгуулийн хорооны нэр дэвшигчээр бүртгэх тухай 07, намын даргын сонгуулийн санал хураалтын дүнг баталгаажуулах тухай 14, сонгуулийн дүнг өргөн мэдүүлэх тухай 15 дугаар тогтоол, ҮБХ-ны 2021.04.02-ны өдрийн 21/09, 21/08, 21/06, 21/07 дугаар тогтоол, АН-ын ээлжит бус Их хурлын 2021.04.03-ны өдрийн 01, 02, 03, 04, 05, 07 дугаар тогтоол, тооллогын болон редакцийн комиссын тогтоолууд, АН-ын даргыг батламжлах ээлжит бус Их хурлын тэмдэглэл, АН-ын гишүүдийн нэгдсэн бүртгэл, даргын сонгуульд санал өгсөн гишүүдийн гарын үсэг бүхий нэрсийн хавтгай болон 2021.04.13, 2021.04.23, 2021.04.26-ны өдрийн албан бичгээр нэмэлт тайлбарыг ирүүлсэн байна.

Дээрх хүсэлттэй холбогдуулан тус намаас дараах албан бичгийг ирүүлсэн байна.

АН-ын ХЭГ-ын дарга П.Нүрзэдийн 2021.03.30-ны өдрийн 2/95, 2021.04.02-ны өдрийн албан бичигт “...Х.Алтанхуяг даргатай Дотоод сонгуулийн хорооноос зохион

байгуулсан 03 дугаар сарын 28-ны өдрийн Ардчилсан намын даргын цахим сонгуулиуд хууль бус, ...И.Мөнхжаргал даргатай ДоСХ-оос намын даргын сонгуулийн санал хураалтыг гишүүдээс биечлэн цаасаар авсан үйл явц хүчинтэй, хууль ёсны болно...”, ...Их хуралд хүрэлцэн ирж, үйл ажиллагаа хууль, дүрэмд заасан хууль ёсны шаардлагад нийцэж буйтай газар дээр нь танилцаж, хяналт тавин, өөрийн биеэр оролцохыг урьж байна”,

АН-ын Үндсэн дүрмийн хорооны /цаашид ҮДХ-ны гэх/ дэд дарга Д.Ганбаярын 2021.04.05-ны өдрийн албан бичигт “..хэсэг бүлэг гишүүд 2021.04.03-ны өдөр Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дүнжингарав худалдааны төвийн гадаа талбайд цагдаагийн мэдээллээр 500 гаруй иргэдийг цуглуулан Намын даргыг сонгох Их хурал гэгчийг зохион байгуулж Улсын дээд шүүхэд бүртгүүлэх ажиллагааг зохион байгууллаа. Энэ нь Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Улсын онцгой комиссын тогтоол шийдвэр, Ардчилсан намын дүрэм зэргийг зөрчсөн байх тул тухайн Их хурлаар сонгогдсон гэх Ардчилсан намын гишүүн О.Цогтгэрэлийг Улсын дээд шүүхэд бүртгэх хуралдааныг хуралдуулахгүй, бичиг баримтын бүрдүүлбэрийг хүлээн авахгүй буцаан ирүүлнэ үү”,

АН-ын ЕНБД Ч.Өнөрбаярын 2021.04.12, 2021.04.14, 2021.04.15, 2021.04.20, 2021.04.21-ний өдрийн албан бичигт “... АН-ыг төлөөлөх эрхгүй этгээдүүд намын даргыг батламжлуулахаар холбогдох материалыг Улсын дээд шүүхэд хүргүүлсэн байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийг зөрчсөн тул тухайн холбогдох материалыг буцаан авах хүсэлтийг гаргаж байна, ...тогтоолуудаар Ц.Тувааныг Ардчилсан намыг төлөөлөх эрхгүй этгээд гэж дүгнэсэн ба уг эрхгүй этгээдийн томилсон П.Нүрзэд гэгч нь мөн адил Ардчилсан намыг төлөөлөх эрхгүй болно. ...П.Нүрзэдийн хүсэлт гаргахдаа ашигласан Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаартай тамгыг Улсын бүртгэлийн газрын хяналтын улсын байцаагчийн 2020.12.24-ний өдрийн 6030 дугаар дүгнэлтээр хүчингүй болгосон, Улсын бүртгэлийн ерөнхий газраас тус намд 9020120477 тоот тамганы хяналтын дугаар олгогдсон одоо ашиглагдаж байна...”, ...Дүнжингарав худалдааны төвд Их хурал гэх үйл ажиллагаа явуулсан Ц.Туваан, Ч.Нүрзэд нарыг Зөрчлийн тухай хуулиар хэрэг нээн шалгаж байна”, “...өмнө гаргасан албан бичгийн хариуг яаралтай шийдэж өгнө үү”,

АН-ын ҮДХ-ны дарга Х.Ганболдын 2021.04.13-ны өдрийн албан бичигт “...АН-ын 2021.04.07-ны ээлжит бус цахим XI Их хурлаар ҮДХ-ны бүрэлдэхүүнийг өөрчилсөн...”,

АН-ын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Бадарсаны 2021.04.23, 2021.04.26-ны өдрийн албан бичигт “...сонсгол зохион байгуулж өгнө үү, ...О.Цогтгэрэлийг АН-ыг даргаар бүртгэж, намын даргатай холбоотой мэдээллийг шинэчилж оруулна уу” гээд нийт 55 хавтас баримт, CD хавсарган ирүүлжээ.

3.2. АН-ын ХЭГ-ын дарга А.Цэрэнбат 2021.04.19-ний өдрийн ХЭГ/109 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтдээ: “Ардчилсан намын дарга М.Тулгатыг ёсчлон батламжилсан, Ардчилсан намын ээлжит бус цахим XI Их хурлын болон ҮБХ-ны

хуралдааны материалыг 2021.04.16-ны өдөр 21 хадгаламжийн нэгж үүсгэн, үдэж хавтаслан хүргүүлсэн ба хавсралтаар дотоод товъёогыг дэлгэрэнгүй гаргаж хүргүүлэв” гэжээ.

Хүсэлтэд “Ардчилсан намын ээлжит бус цахим XI Их хурлаас Ардчилсан намын даргаар Майнбаярын Тулгатыг ёсчлон батламжилсантай холбогдуулан Намын баримт бичигт өөрчлөлт оруулах тухай” С.Эрдэнийн өргөдөл,

-АН-ын үндсэн дүрмийн хорооны 2021.04.05-ны өдрийн 21 дүгээр тогтоол,

-АН-ын Дотоод сонгуулийн хорооны /цаашид ДоСХ гэх/ 2021.03.18-ны өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 14 дүгээр тогтоол, тэмдэглэлийн хамт,

-АН-ын ДоСХ-ны 2021.03.20-ны өдрийн “АН-ын даргад нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгох тухай” 15 дугаар тогтоол, тэмдэглэлийн хамт,

-АН-ын ДоСХ-ны 2021.03.28-ны өдрийн “Цахим сонгуулийн дүнг нэгтгэн гаргаж, өргөн мэдүүлэх тухай” 19 дүгээр тогтоол, тэмдэглэлийн хамт,

-АН-ын ДоСХ-ны 2021.04.01-ний өдрийн “Ардчилсан намын ээлжит бус Их Хурлын төлөөлөгчдийн мандатын тоо батлах тухай” 20 дугаар тогтоол, тэмдэглэл,

-АН-ын ДоСХ-ны 2021.04.05-ны өдрийн “Цахим санал хураалтын тов тогтоох, зохион байгуулах тухай” 21 дүгээр тогтоол, хавсралт, цахим хуралд томилогдох төлөөлөгчдийн нэрс, тэмдэглэлийн хамт,

-АН-ын ДоСХ-ны 2021.04.06-ны өдрийн “АН-ын ээлжит бус цахим XI Их хурлын төлөөлөгчдийг өргөн мэдүүлэх тухай” 22 дугаар тогтоол, хавсралт, тэмдэглэлийн хамт,

-АН-ын ДоСХ-ны 2021.04.06-ны өдрийн “Цахим сонгуулийн дүнг өргөн мэдүүлэх тухай” 23 дугаар тогтоол, тэмдэглэлийн хамт,

-ҮБХ-ны 2021.03.04-ний өдрийн ээлжит бус цахим хуралдааны 01, 02, 03, 04, 05, 09, 10, 11 тогтоолууд, тооллогын комиссын тогтоол, тэмдэглэлийн хамт,

-ҮБХ-ны 2021.03.12-ны өдрийн ээлжит бус цахим хуралдааны “тооллогын комисс байгуулах тухай” 01 тогтоол, “редакц байгуулах тухай” 02 тогтоол, “хурлын дарга, тэргүүлэгчдийг сонгох тухай” 03 тогтоол, тэмдэглэлийн хамт,

-ҮБХ-ны 2021.03.12-ны өдрийн ээлжит бус цахим хуралдааны “Хэлэлцэх асуудал батлах тухай” 04 дүгээр тогтоол, цахим хэлбэрээр зохион байгуулах тухай 06 дугаар тогтоол, дотоод сонгуулийн хорооны гишүүдийг томилж, чөлөөлөх тухай 07 дугаар тогтоол, тооллогын комиссын тогтоол, тэмдэглэлийн хамт,

-ҮБХ-ны ээлжит бус цахим хуралдааны хурлын 2021.04.01-ний өдрийн тооллогын комисс байгуулах тухай тогтоол, редакц байгуулах тухай, хурлын дарга, тэргүүлэгчдийг сонгох тухай тогтоол, хэлэлцэх асуудал батлах тухай тогтоол, АН-н

даргын сонгуулийн дүнг танилцуулах тухай 05 тогтоол , АН-н ээлжит бус цахим XI Их хурлын тов зарлах тухай,

-ҮБХ-ны 2021.03.12-ны Үндсэн дүрмийн хорооны гишүүн томилох тухай 11 тогтоол, тооллогын комисс тогтоол, тэмдэглэл,

-ДоСХ-ны 2021.04.05-ны өдрийн “цахим санал хураалтын тов тогтоох, зохион байгуулах тухай” 21 дүгээр тогтоол,

-ҮБХ-ны 2021.04.06-ны өдрийн Ардчилсан намын даргыг ёсчлон батламжлах тухай 12 дугаар тогтоол,

-АН-ын даргыг ёсчлон батламжлах ээлжит бус Их хурлын тэмдэглэл,

-АН-ын ээлжит бус цахим Их хурлын 2021.04.07-ны өдрийн 07 дугаар тогтоол зэрэг 21 хавтас баримтыг ирүүлжээ.

Дээр дурдсан баримтууд нь О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг намын даргаар бүртгүүлэх талаар гаргасан хүсэлттэй холбоотой байх тул нэгтгэж дүгнэлт хийх нь зүйтэй гэж үзэв.

3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.6-д “хуулийн этгээдийн мэдээлэл гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа энэ хуулийн 10.1-д заасан болон бусад мэдээллийг хэлнэ” гэж, хуулийн 10.1.10-т “хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар,...” гэж заасан тул намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг Улсын дээд шүүх бүртгэнэ.

АН-ын дүрмийн 5.12.4.8-д намын даргыг ёсчлон батламжлах нь Их хурлын бүрэн эрхэд хамаарахаар зохицуулсан байна.

Иймд Их хурал зарлан хуралдуулсан болон намын даргын сонгууль хууль болон Үндсэн дүрэмд нийцсэн эсэхийг тогтоох шаардлагатай.

Дүрмийн 5.12.2-т Их хурлын ээлжит хуралдаан 4 жилд 2-с доошгүй удаа хуралдана. Их хурлын ээлжит, ээлжит бус хуралдааныг ҮБХ-ны нийт гишүүдийн ердийн олонхийн /50-с дээш хувь/-ийн саналаар эсвэл намын дарга зарлан хуралдуулна гэжээ.

А/ АН-ын ҮБХ-ны 2021.03.11-ний 20/10 дугаар тогтоолоор намын ээлжит бус Их хурлыг 2021.04.03, 04-ний өдрүүдэд товлон зарлаж, Их хурлын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсан, тогтоолд дарга Д.Бадарсан, тэргүүлэгч Б.Жаргалан, Д.Батцогт нар гарын үсэг зурсан байна.

И.Мөнхжаргал даргатай ДоСХ-ны 2021.02.24-ний өдрийн 03, 2021.03.02-ны өдрийн тогтоолоор намын даргын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн сурталчилгаа явуулах, санал хураалтыг зохион байгуулах хугацааг тогтоосон, 2021.03.30-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор санал хураалтын дүнг баталгаажуулж,



нийтэд зарлахыг хорооны даргад даалгасан, 2021.03.31-ний өдрийн 15 дугаар тогтоолоор намын даргад О.Цогтгэрэлийг Их хуралд өргөн мэдүүлэхийг үүрэг болгожээ.

Б/ АН-ын ҮБХ-ны ээлжит бус цахим хурлын 2021.04.01-ний өдрийн 06 дугаар тогтоолоор Ардчилсан намын ээлжит бус цахим XI Их хурлыг 2021.04.07-ны өдөр товлон зарлаж, зохион байгуулахыг ДоСХ-ны дарга Х.Алтанхуягт чиглэл болгож, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, чиг үүргээр хангаж ажиллахыг Ардчилсан намын дарга С.Эрдэнэд даалгасан, тогтоолд дарга Ц.Оюундарь, тэргүүлэгч А.Цэрэнбат, Б.Нямсүрэн нар гарын үсэг зурсан байна.

Х.Алтанхуяг даргатай ДоСХ-ны 2021.03.20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Намын даргын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгосон, 2021.04.05-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор 2021.04.06-ны өдрийн 10.00 цагаас 22 цагийн хороонд цахим санал хураалтыг товлон зарлаж, Их хуралд сонгогдсон төлөөлөгчдийн нэрсийг хавсралтын дагуу цахим сонгуулийн системд оруулж, санал хураалтыг зохион байгуулахыг үүрэг болгосон, 2021.04.06-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Ардчилсан намын даргын цахим сонгуулийн дүнг нэгтгэхэд 2,133.82 оноо буюу хамгийн өндөр оноо авсан М.Тулгатыг АН-ын даргаар сонгогдсонд тооцож, нэр дэвшигч М.Тулгатыг АН-ын ээлжит бус XI Их хуралд өргөн мэдүүлэхийг ДоСХ-ны даргад үүрэг болгожээ.

Дүрмийн 5.12.4.3, 5.12.4.4-т зааснаар ҮБХ, ҮДХ, ДоСХ-ны бүрэлдэхүүнийг намын даргын санал болгосноор Их хурал хэлэлцэж батлах ба 5.13.2, 5.13.5-т ҮБХ нь үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол УИХ-ын сонгуулийн тойргийн мандатын тоог 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тооны гишүүдтэй байна, ҮБХ-ны гишүүний бүрэн эрх 4 жил байна гэжээ.

Дүрмийн 5.12.4.4-т ДоСХ-ны бүрэлдэхүүнийг намын даргын санал болгосноор Их хурал батална,

5.22-т сонгуулийн байгууллага нь төрийн болон намын бүх шатны сонгуульд оролцох үйл ажиллагааг зохион байгуулна,

5.22.5.6-т ДоСХ нь 15 гишүүний бүрэлдхүүнтэй байна,

5.22.5.7-т ДоСХ-ны дарга, дэд дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна,

5.22.5.8-д даргыг гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн сонгоно,

5.22.5.10-т ДоСХ-ны үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх ба шийдвэрээ тогтоолоор гаргана, Тогтоолд дарга дэд дарга гарын үсэг зурна, хуралдааны тэмдэглэлд дарга хурлын нарийн бичгийн дарга гарын үсэг зурна,

5.22.5.11-д хуралдааныг ДоСХ-ны дарга зарлан хуралдуулна,

5.22.5.12-т хуралдааныг гишүүдийн 2/3-с дээш буюу 10 ба түүнээс дээш гишүүний ирцтэйгээр эхэлж, ердийн олонхийн саналаар шийдвэрээ гаргана гэж тус тус заажээ.

Хүсэлтэд хавсаргасан баримтуудаас үзвэл, Их хурал, намын даргын сонгуулийг зохион байгуулсан сонгуулийн байгууллагын шийдвэрүүд хоорондоо зөрчилтэй, намын төлөөллийн төв байгууллага болох ҮБХ нь 2 өөр бүрэлдэхүүнээр тус тусдаа асуудлыг шийдвэрлэсэн нь намын Үндсэн дүрэмд нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, Их хурлыг зарлан хуралдуулсан, намын даргыг сонгох сонгуулийн үйл явц нь намын Үндсэн дүрмээр зохицуулагдах тус намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой маргаан гэж үзэв.

Иймд О.Цогтгэрэл, М.Тулгат нарын хэн алиныг намын даргаар бүртгэх боломжгүй гэж нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-д “намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой маргааныг шүүх хянан шийдвэрлэхгүй. Энэхүү маргааныг намын эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэнэ” гэж заасан тул АН-ын хувийн хэрэг дэх мэдээлэлд өөрчлөлт оруулах буюу намын даргаар О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг тус тус бүртгүүлэхээр ирүүлсэн АН-ын хүсэлтүүдийг хангахаас татгалзах нь зүйтэй.

Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, Их хурлыг товлон хуралдуулах, намын даргыг сонгох зэрэг дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Үндсэн дүрэмд нийцүүлэн намын эрх бүхий байгууллагаараа хянан шийдвэрлүүлэх нь хуульд нийцнэ.

Дөрөв. Бусад хүсэлтийн талаар:

АН-ын ДоСХ-ны дарга Х.Алтанхуяг 2021.04.02-ны өдрийн 21, ЕНБД Ч.Өнөрбаяр 2021.04.15-ны өдрийн 91 тоот албан бичигт “...АН-ын дарга С.Эрдэнийн цахим санд бүртгэсэн бүртгэлийг сэргээж өгнө үү”, мөн 2021.04.26-ны өдрийн 112 тоот албан бичигт “... Улсын дээд шүүхийн цахим мэдээллийн санд С.Эрдэнийг үүсгэн байгуулагчийн архивд байх бичгэн баримтыг үндэслэн өмнө нь байсан бүртгэлийг сэргээж өгнө үү” гэх хүсэлтүүдийг ирүүлжээ.

О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг АН-ын даргаар бүртгүүлэх тухай хүсэлтийг хэлэлцэх явцад тус намаас ирүүлсэн дээрх хүсэлтүүд агуулгын хувьд ижил байх тул нэгтгэн нэг мөр дүгнэлт өгөх нь зүйтэй байна.

4.1. АН-ын хувийн хэргийн мэдээллээс үзвэл, намын даргаар С.Эрдэнэ томилогдсоныг Улсын дээд шүүхийн 2017.03.15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилт хийжээ.

АН-ын ХЭГ-ын дарга П.Нүрээдийн “намын даргын үүрэг гүйцэтгэгчийг бүртгүүлэх” тухай хүсэлт, тус намын ҮБХ-ны 2020.07.24-ний өдрийн 16/06 тоот тогтоолыг үндэслэн Улсын дээд шүүх цахим бүртгэлд намын даргын үүрэг гүйцэтгэгчээр Ц.Тувааныг бүртгэжээ.

УДШ-ийн 2021.01.14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор цахим бүртгэлд АН-ын даргаар бүртгүүлэх тухай С.Эрдэнийн хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэхдээ "...намыг төлөөлөх эрхтэй этгээд, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх асуудал маргаантай" гэж дүгнэсэн байна.

Үүний дараа С.Эрдэнэ "...цахим бүртгэлд намын дарга С.Эрдэнэ" гэсэн өөрчлөлт хийлгэх хүсэлт гаргасан, УДШ-ийн 2021.02.26-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар нам дотооддоо шийдвэрлэх талаарх тус шүүхийн 04 дүгээр тогтоолд заасан зөрчил арилаагүй гэж үзэж, хүсэлтийг хангахаас татгалзсан, дээрх тогтоолууд хуулийн хүчин төгөлдөр байна.

Дээрх тогтоолуудад заасан зөрчил арилаагүй, энэ талаар уг хүсэлтэд дурдаагүй байна.

4.2. АН-аас "...УДШ-ийн цахим сан дах С.Эрдэнийн бүртгэлийг сэргээх тухай" хүсэлтийг дахин гаргахдаа "...шүүгч Х.Сонинбаяр захиргааны акт гаргалгүйгээр С.Эрдэнийн бүртгэлийг өөрчилж, бүртгэлд Ц.Туваан гэж сольсон үйлдэл нь хуульд заагдаагүй ажиллагаа болсныг Шүүхийн ёс зүйн хорооны тогтоолоор тогтоогдсон" гэх үндэслэлийг дурджээ.

Цахим бүртгэлд АН-ын даргын үүрэг гүйцэтгэгчээр Ц.Тувааныг бүртгэсэн байх боловч С.Эрдэнэ эс зөвшөөрч хүсэлт гаргасан, УДШ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор Ц.Тувааны бүртгэлийг хүчингүй болгож, АН-ын даргаар бүртгэсэн бүртгэлийг сэргээлгэх С.Эрдэнийн хүсэлтийг мөн адил хангахгүй орхисон бөгөөд намын удирдлагын талаар намд дотоод маргаан үүссэн гэж дүгнэжээ.

Намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой маргааныг шүүх хянан шийдвэрлэхгүй талаар Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-д заасан тул нам дотоод маргаанаа өөрсдөө шийдвэрлэх үүрэгтэй.

Хүсэлтэд хавсаргаж ирүүлсэн Шүүхийн ёс зүйн хорооны 2021.04.02-ны өдрийн 26 дугаар тогтоолоор шүүгч Х.Сонинбаярт сахилгын хэрэг үүсгэсэн байх боловч сахилгын хэрэг үүсгэсэн байх, сахилгын арга хэмжээ авсан эсэх асуудал намын бүртгэлд хамааралгүй, энэ нь хүсэлтийг хангах үндэслэл болохгүй юм.

Дээр дурдсан үндэслэлээр хүсэлтүүдийг тус тус хангахаас татгалзах нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэлээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 13 дугаар зүйлийн 13.9, 21 дүгээр зүйлийн 21.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Ардчилсан Намын Их хурлаас сонгогдсон Үндсэн дүрмийн хороо болон Дотоод сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд Үндэсний бодлогын хорооны 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит бус цахим хурлаар өөрчлөлт оруулсныг бүртгүүлэх хүсэлтийг хангахаас татгалзсугай.

2.Ардчилсан намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсугай.

3.Ардчилсан намын даргаар О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг тус тус бүртгүүлэх тухай хүсэлтийг хангахаас татгалзсугай.

4.Улсын дээд шүүхийн цахим сан дахь С.Эрдэнийн бүртгэлийг сэргээх тухай хүсэлтийг хангахаас татгалзсугай.

5.Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид 2021 оны 04 сарын 23-ны өдөр төлсөн 150 000 төгрөг, 2021 оны 04 сарын 15-ны өдөр төлсөн 150 000 төгрөгийг тус тус улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧИД

Х.БАТСҮРЭН

Г.ЦАГААНЦООЖ

Д.ЦОЛМОН